

# SMITTSKYDDSBLAD

## Patientinformation

Latent tuberkulos när behandling ej ges

Översatt till mongoliska

Version 2022-04-11

## Идэвхгүй сүрьеэ, өвчтөнд өгөх мэдээлэл

**Урьдчилан сэргийлэх эмчилгээ хийхгүй байх нь. Халдвар хамгааллын эмч нарын мэдээллийн хуудас.**

### Сүрьеэ хэрхэн халдварлах вэ?

Уушгиндаа сүрьеэтэй хүн тасалгаанд ханиалгахад бусдад халдвар тараана. Өөр эхргэнд байрлах сүрьеэ ба идэвхгүй сүрьеэ халдварлахгүй. Бэлгийн бойжилтын өмнөх насны хүүхэд халдварлах нь ховор. Халдвар авах эрсдэл нь нэг өрөөнд удаан хугацаанд хамт байх, жишээ нь нэг өрхөд амьдрахад өндөр байна.

### Идэвхгүй сүрьеэ гэж юу вэ?

Халдвар авсан бүх хүн сүрьеэгээр өвчлөхгүй. Ихэнх хүмүүсийн биеийн дархлаа бактерийн өсөлтийг зогсооно. Бактери биенд үлдэж, идэвхгүй байж болно. Ийм нөхцөл байдлыг **идэвхгүй сүрьеэ** гэнэ.

### Идэвхгүй сүрьеэ бол өвчин биш

Цусны шинжилгээ (IGRA шинжилгээ) эсвэл арьсны сорил (сүрьеэний сорил) хийлгэсний дараа идэвхгүй сүрьеэтэй гэсэн хариу авсан танд сүрьеэний шалтгаантай өвчний шинж тэмдэг илрэх ёсгүй. Та эдгээр бактерийг бусдад тараахгүй.

Амьдралынхаа хожуу үед сүрьеэ тусах эрсдэл бий, гэхдээ энэ эрсдэл нь жижиг. Ихэнх тохиолдолд тиймээс идэвхгүй сүрьеэтэй хүнд эмчилгээ хийх шаардлагагүй.

### Зарим тохиолдолд урьдчилан сэргийлэх эмчилгээ хийдэг

Хожим өвчлөх өндөрсөн эрсдэлтэй зарим хүнд урьдчилан сэргийлэх эмчилгээ санал болгогддог. Эхний ээлжинд эмэгтэйчүүдэд жирэмсэн үед нь ба төрснийх нь дараа, хүүхэд залуучуудад, мөн суларсан дархлаатай буюу хорт хавдрын эмчилгээ, инсулинаар эмчлэх чихрийн шижинтэй, бөөрний хүнд өвчинтэй хүмүүст хамаатай. Урьдчилан сэргийлэх эмчилгээг заримдаа саяхан сүрьеэний халдварт өртсөн хүнд хийдэг.

### Эмчтэй холбоотой байх нь

Та идэвхгүй сүрьеэтэй ба эмч таныг эмчилгээ хийлгэх шаардлагагүй гэж үзэж байна. Та хожим удаан хугацааны ханиалга (гурваас илүү долоо хоног), шөнийн хөлрөл, халуун, эсвэл хүсэхгүйгээр жин хасагдвал эмчтэй холбогдож сүрьеэний шинжилгээ хийлгүүлэх хэрэгтэй. Та жирэмсэлсэн, эсвэл инсулинаар эмчлэх чихрийн шижинтэй болсон эсвэл бөөрний хүнд өвчин туссан, эсвэл хорт хавдрын эмчилгээ хийлгэж буй эсвэл өөр шалтгаанаар суларсан дархлаатай болсон бол мөн эмчтэй холбогдох хэрэгтэй. Эдгээр тохиолдолд та сүрьеэгээр өвчлөх өндөр эрсдэлтэй.

### Холбоо барих мэдээлэл (*Kontaktuppgifter*)

Хүлээн авахын нэр (*Namn på mottagningen*)

.....

Утасны дугаар / хүлээн авахын утасны цаг (*Telefonnummer/telefonid till mottagningen*)

.....